



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2018 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/106

Чингис хот

**Хөрөнгө зарцуулах тухай**


Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 онд баталсан "Цагдаагийн алба хаагч, ажилтны нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийг хамгаалах хөтөлбөр". Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам "Алба хаагчийг сувилах, эрүүл мэндийг нөхөн сэргээх" /код 938.3.1./ дэх заалт, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/102 дугаар тушаалаар батлагдсан "Байгууллагын даргын тушаал гаргах журам /код-136/"-ын 136.4.2-ын "е" заалт, 136.5.2-ын "в" заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын алба хаагчдын эрүүл мэндийг нөхөн сэргээх, сувилах зориулалттай Дэлгэрхаан сум дахь "Амар" амралтын газарт тус цагдаагийн газрын харьяалал бүхий ажилтан, алба хаагч, тэдгээрийн гэр бүл, ахмад настангуудыг хуваарийн дагуу, бусад цагдаагийн байгууллагын алба хаагчдын хүсэлтийг үндэслэн зөвшөөрлөөр амарч сувилуулах нөхцөл бололцоогоор хангахыг Төлөвлөлт зохион байгуулалтын тасгийн дарга, цагдаагийн хошууч Т.Чинбаатарт үүрэг болгосугай.

2. Амралтын үйл ажиллагааг хариуцан ажиллуулахыг "Амар" амралтын менежер Г.Пүрэвжавт даалгасугай.

3. Амарч сувилуулж байгаа цагдаагийн алба хаагчдын хүнсэнд зориулж туслах аж ахуйгаас 12 /арван хоёр/ хонь зарцуулахыг ахлах няглан бодогч, цагдаагийн хошууч Ж.Баатарт зөвшөөрсүгэй.

4. Тушаалыг бүрэлдэхүүнд танилцуулсугай.

ДАРГА,  
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА  Ж.БОЛД